



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/019/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

| | |
|---|----------|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан..... | 5 |
| 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 6 |
| 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 7 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 8 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 9 |
| 5.2 Залруулаагүй алдаа | 9 |
| 5.2.1 Төлбөрийн акт | 9 |
| 5.2.2 Албан шаардлага | 9 |
| 5.2.3 Зөвлөмж | 9 |

Товчилсон үгийн жагсаал

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХНТГТҮХ | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талын үндэсний хороо |
| ЗГУМС | Засгийн газрын удирдлага мэдээллийн систем |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР**
41100, Төв аймаг, Буулвод сум
Утас: 70272582, Цахиаг мөхүүрэн: tuv.audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.03.27 № 01/2026
Танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.НАРАНБААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төсөвт тодотгол хийснээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 03 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 202,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,444,700.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Лүн сум нь 16 нэр төрлийн 1,444,700.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,553,946.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 107.6 хувь буюу 109,245.8 мянган төгрөгөөр давж биелсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл 13 нэр төрлийн орлого 117,660.9 мянган төгрөгөөр давж, 3 нэр төрлийн орлого 46,584.86 мянган төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Лүн сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ нь 174 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батламжлагдсанаас гүйцэтгэлээр 134 арга хэмжээг 100 хувь, 40 арга хэмжээг 70-88 хувьтай хэрэгжүүлсэн байна. Нийт үнэлгээгээр 93.0 хувьтай буюу "Үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.



G/Arkhir/Albanbichig2026/A4

• 4126020594

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 2024.12.31 | 2025.12.31 |
|------------|---|-------------|-------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,200,435.4 | 1,178,605.9 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 614,212.8 | 678,727.1 |
| 33 | АВЛАГА | 405,398.5 | 314,585.5 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 180,824.2 | 185,293.3 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 6,791,587.7 | 7,495,528.9 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 6,791,587.7 | 7,495,528.9 |
| 39200 | Биет хөрөнгө | 5,806,041.6 | 6,482,792.9 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 985,546.1 | 1,012,736.1 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 7,992,023.1 | 8,674,134.8 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 17,957.8 | 64,827.9 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 17,957.8 | 64,827.9 |
| 41300 | Өглөг | 17,957.8 | 64,827.9 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 7,974,065.3 | 8,609,306.9 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 7,974,065.3 | 8,609,306.9 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 608,018.8 | 608,018.8 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 7,008,017.4 | 7,645,634.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 358,029.2 | 355,653.9 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 7,992,023.1 | 8,674,134.8 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | | 2024.12.31 | 2025.12.31 |
|------------|--|-------------|-------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 8,980,903.8 | 7,078,383.9 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 963,497.5 | 893,670.1 |
| 110 | Орлогын албан татвар | 519,723.0 | 592,884.3 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 519,723.0 | 592,884.3 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 113,876.4 | 131,848.7 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 329,898.1 | 168,937.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 14,081.4 | 15,496.5 |
| 1181 | Газрын төлбөр | 99,850.4 | 14,458.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 215,966.4 | 138,982.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,432,402.4 | 6,184,713.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,380,003.2 | 1,636,733.6 |
| 122 | Тусламжийн орлого | 52,399.2 | 4,241,340.6 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 4,241,340.6 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0.0 | 307,523.7 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,585,003.9 | 0.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 696,751.7 | 0.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 6,705,481.4 | 6,446,595.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,984,950.9 | 6,050,129.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,821,780.8 | 3,011,483.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,035,398.6 | 1,190,271.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,143.5 | 190,456.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 659,754.8 | 703,874.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 97,018.4 | 69,099.6 |
| 2105 | Нормативт зардал | 76,192.4 | 99,491.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 67,252.1 | 55,890.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,584.0 | 12,214.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 65,494.0 | 12,121.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 679,943.0 | 678,063.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,163,170.1 | 3,038,645.8 |

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|------|--|-------------|-----------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 99,847.1 | 82,147.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 720,530.5 | 396,466.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 720,530.5 | 396,466.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 2,275,422.5 | 631,788.5 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 125,300.3 | 11,254.7 |
| VII | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | -125,300.3 | -11,254.7 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 2,150,122.2 | 620,533.8 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|----|---|---------------------------------|-----------------------|----------------------|--|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 608,018.8 | 358,029.1 | 4,857,895.1 | 5,823,943.0 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 608,018.8 | 358,029.1 | 4,857,895.1 | 5,823,943.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 2,150,122.2 | 2,150,122.2 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 608,018.8 | 358,029.1 | 7,008,017.3 | 7,974,065.2 |
| 11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 608,018.8 | 358,029.1 | 7,008,017.3 | 7,974,065.2 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 17,083.1 | 17,083.1 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 608,018.8 | 358,029.1 | 7,025,100.4 | 7,991,148.3 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | -2,375.3 | 0.0 | -2,375.3 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 620,533.8 | 620,533.8 |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 608,018.8 | 355,653.8 | 7,645,634.2 | 8,609,306.8 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|-------------|-------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 7,210,820.8 | 6,304,742.5 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 963,497.5 | 893,670.1 |
| 110 | Орлогын албан татвар | 519,723.0 | 592,884.3 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 519,723.0 | 592,884.3 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 113,876.4 | 131,848.7 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 329,898.1 | 168,937.1 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 14,081.4 | 15,496.5 |
| 1181 | Газрын төлбөр | 99,850.4 | 14,458.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 215,966.4 | 138,982.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 676,069.7 | 5,411,072.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 633,669.7 | 863,092.2 |
| 122 | Тусламжийн орлого | 42,400.0 | 4,241,340.6 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 4,241,340.6 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 306,639.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,571,253.5 | 0.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 381,859.4 | 0.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 697,709.1 | 0.0 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 4,428,438.9 | 0.0 |

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|------|--|--------------|-------------|
| 1330 | Төсвийн захирагчдаас | 63,246.2 | 0.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,604,509.7 | 5,685,702.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,604,509.7 | 5,685,702.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,456,047.4 | 2,647,056.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,036,304.5 | 1,206,815.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 123,345.0 | 149,187.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 673,675.8 | 700,864.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 80,459.0 | 56,200.1 |
| 2105 | Нормативт зардал | 77,007.9 | 101,121.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 98,638.7 | 79,264.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,584.0 | 12,214.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,905.8 | 11,416.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 342,126.7 | 329,971.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,148,462.3 | 3,038,645.8 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.0 | 2,956,498.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 99,847.1 | 82,147.7 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,048,615.2 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 1,606,311.1 | 619,040.5 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 1,239,757.3 | 553,873.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,239,757.3 | 553,873.4 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,239,757.3 | 553,873.4 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -1,239,757.3 | -553,873.4 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 304.0 | 652.8 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -304.0 | -652.8 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 366,249.8 | 64,514.3 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 247,963.0 | 614,212.8 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 614,212.8 | 678,727.1 |
| 100 | Тохируулгын орлого, зарлагын зөрүү | 0.0 | 2,574.5 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Тайлангийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|------------|--|-------------|-------------|-------------|-------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 5,606,061.6 | 5,652,953.8 | 46,892.2 | 100.8 |
| 11 | Татварын орлого | 742,200.2 | 893,670.1 | 151,469.9 | 120.4 |
| 110 | Орлогын албан татвар | 472,738.9 | 592,884.3 | 120,145.4 | 125.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 472,738.9 | 592,884.3 | 120,145.4 | 125.4 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 69,680.0 | 131,848.7 | 62,168.7 | 189.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 199,781.3 | 168,937.1 | -30,844.2 | 84.6 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 8,100.0 | 15,496.5 | 7,396.5 | 191.3 |
| 1181 | Газрын төлбөр | 14,453.9 | 14,458.4 | 4.5 | 100.0 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 177,227.4 | 138,982.2 | -38,245.2 | 78.4 |
| 12 | Татварын бус орлого | 4,863,861.4 | 4,759,283.7 | -104,577.7 | 97.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 600,000.0 | 740,223.5 | 140,223.5 | 123.4 |
| 122 | Тусламжийн орлого | 3,955,132.4 | 3,712,420.5 | -242,711.9 | 93.9 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 308,729.0 | 306,639.6 | -2,089.4 | 99.3 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,329,831.8 | 5,661,772.5 | 2,331,940.7 | 170.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,675,109.3 | 5,198,171.7 | 2,523,062.4 | 194.3 |

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|------|--|--------------|-------------|-------------|--------|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,589,176.0 | 2,433,657.0 | -155,519.0 | 94.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,143,388.4 | 1,108,821.4 | -34,567.0 | 97.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 141,623.5 | 136,893.2 | -4,730.3 | 96.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 705,638.6 | 700,864.8 | -4,773.8 | 99.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 65,060.0 | 54,407.4 | -10,652.6 | 83.6 |
| 2105 | Нормативт зардал | 1,690.0 | 1,373.0 | -317.0 | 81.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 105,289.4 | 79,264.8 | -26,024.6 | 75.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,054.0 | 12,214.0 | -3,840.0 | 76.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,087.9 | 11,416.8 | -13,671.1 | 45.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 385,344.2 | 328,401.6 | -56,942.6 | 85.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 85,933.3 | 2,764,514.7 | 2,678,581.4 | 3217.0 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.0 | 2,682,367.0 | 2,682,367.0 | 0.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 85,933.3 | 82,147.7 | -3,785.6 | 95.6 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 554,722.5 | 462,948.1 | -91,774.4 | 83.5 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 100,000.0 | 652.8 | -99,347.3 | 0.7 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 2,276,229.8 | -8,818.7 | 2,285,048.5 | -0.4 |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | -2,276,229.8 | 8,818.7 | 2,285,048.5 | -0.4 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -2,276,229.8 | 8,818.7 | 2,285,048.5 | -0.4 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 593,485.5 | 593,485.5 | 0.0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 637,401.4 | 637,401.4 | 0.0 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 81 | 77 | 4 | 0.0 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 3 | 3 | 0.0 | 0.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 39 | 37 | 0.0 | 0.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 39 | 37 | 0.0 | 0.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Тайлангийн үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|-----------|------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 697,709.1 | 254,789.1 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 697,709.1 | 254,789.1 |
| 122 | Тусламжийн орлого | 697,709.1 | 254,789.1 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 697,709.1 | 254,789.1 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 697,709.1 | 254,789.1 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 697,709.1 | 202,054.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 252,748.3 | 111,129.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 156,157.5 | 111,129.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 88,597.5 | 96,843.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,996.9 | 12,013.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,132.9 | 1,792.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,691.0 | 480.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 444,960.8 | 90,925.4 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 444,960.8 | 90,925.4 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 0.0 | 52,734.7 |

| | | | |
|---|---|-----|-----------|
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.0 | -52,734.7 |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 0.0 | -52,734.7 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 56,415.8 мянган төгрөгийн алдаа илрүүлснийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

1.1 Залруулсан алдаа

- Лүн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг шалгаж үзэхэд тайлант үеийн үр дүн 1,415.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд илэрхийлэгдсэн цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын орлогын төлөвлөгөө татварын албанаас ирүүлсэн гүйцэтгэлийн мэдээтэй 55,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.2 Залруулаагүй алдаа

Аудитаар нийт орлого бүрдүүлэлтэй холбоотой 1 шилэн дансны хөтлөлттэй холбоотой 1 нийт 2 албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулаагүй алдаа нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

5.2.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт:1

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөгөөр 1,444,700.2 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,553,945.9 мянган төгрөг төвлөрүүлсэн ба 16 нэр төрлийн орлогоос хадгаламжийн хүүгийн орлого 6,654.1 мянган төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого 1,625.6 мянган төгрөгөөр, ан агнуурын нөөц ашигласны төлбөр 38,305.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс. орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

5.2.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | | |
|---|---|--------------------------|-----------------------------|--------------------|-------------------------|-----------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс тагталзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 2 | Засаг даргын тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 3 | Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Эмийн эргэлтийн сан | 1 | | 1 | | | | | |
| 6 | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | | |
| 7 | Ойн анги | 1 | | 1 | | | | | |
| | НИЙТ | 7 | 1 | 6 | | 1 | | | |

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл | | | | | | | /мянган төгрөгөөр/ | | | |
|---------------------------------------|------------|------------------|-----------------------------------|-----------------|--------------------------|------------------|--------------------|------------------|--------------|----------|
| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Засаг дарга | 2 | 56,415.1 | 1 | 55,000.0 | 1 | 1,415.0 | 1 | 56,415.1 | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | 24,989.2 | 0 | - | 1 | 24,989.2 | 1 | 24,989.2 | | |
| Ойн анги | 3 | 24,799.9 | 1 | 19,108.0 | 2 | 5,691.9 | 3 | 24,799.9 | | |
| Дүн | 6 | 106,204.2 | 2 | 74,108.0 | 4 | 32,096.19 | 5 | 106,204.2 | - | - |

| Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл | | | | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--|-------------|----------|---------------|---------|--------------------|----------|---------|----------|--|--|
| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Засаг дарга | 2 | 46,584.9 | 0 | 0 | 2 | 46,584.9 | 0 | 0.00 | | |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 2 | 7,471.7 | 1 | 3,490.4 | | | 1 | 3,981.3 | | |
| Засаг даргын Тамгын газар | 1 | 23,192.5 | 0 | | | | 1 | 23,192.5 | | |

